

БАТЛАВ:  
ГОВИЙН БАГА ДАРХАН ЦААЗАТ  
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГА Ч.БАТСҮХ

2024 оны 06 дугаар сарын 14

**ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ГҮН ӨРМИЙН ХУДАГ ШИНЭЭР ГАРГАХ ХУДГИЙН  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА**

2024.06.14

Дөрөлж

1	Ажлын даалгавар боловсруулах үндэслэл зорилго	Сангийн сайдын 2023 оны 12 сарын 05 -ны өдрийн № 234 тушаалаар батлагдсан " Улсын төсвийн байгууллагын давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай" , Сангийн сайдын 2024 оны 04 сарын 12 -ны өдрийн № 67 тушаалаар батлагдсан " Дансны үлдэгдэл буцаан олгох тухай" , ТӨБЗГазрын 2024 оны 01 сарын 24-ны өдрийн № А-1/127 зөвшөөрөл олгосон албан тоот
2	Захиалагч байгууллага	Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
3	Зориулалт	ГБДЦГ-н "Б" хэсэгт байрлах бөгөөд зэрлэг амьтан ундаалах
4	Гүн өрмийн худгийн байршил	Дорноговь аймгийн Хатанбулаг сум ГБДЦГ-н "Б" хэсэг харсүүлт, хулангийн байршил нутаг
5	Гүн өрмийн худгийн тоо	Гадна тохижилт бүхий гүн өрмийн 2 худаг
6	Хөрөнгийн эх үүсвэр	2023 оны Байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос 115,224,367 ( нэг зуун арван таван сая хоёр зуун хорин дөрвөн мянга гурван зуун жаран долоон ) төгрөг

**1.Цооног өрөмдөх, цооногийг тоноглох**

1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох
1.2	Цооногийг 219 мм-ээс багагүй голчтой өрөмдөх, бэхэлгээ янданг заавал суулгана. Өрөмдлөгийн үед хурдас чулуулаг өөрчлөгдөх тутамд хөрсний дээжийг авна. Цохилтод өрмөөр өрөмдсөн тохиолдлд цооногийн нийт гүнд суултын янданг суурилуулна.
1.3	Цооногийн ашиглалтын ундарга: 2л.сек дээш ус өгөх хүчин чадалтай байна.
1.4	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой, 168 мм-ээс багагүй голчтой янданг ашиглах
1.5	Шүүрийн яндангийн диаметр нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.
1.6	Ус өргөх яндангийн диаметр 32 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/ стандартын шаардлага хангасан байна
1.7	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй% мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна.
1.8	Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй
1.9	Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй, уст үеийн хүчин чадлыг тогтоох шавхалтыг шаталсан болон тогтмол ундаргатай шавхалтаар хийнэ.
1.10	Усны чанарын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх
1.11	Худгийн цооногийг түр хугацааны тагаар тоноглох

**2. Худгийн байшин, усан сан, зэрлэг амьтан ундаалах онгоц, талбай барих**

2.1	Худгийн байшин <ul style="list-style-type: none"><li>Хэмжээ / дотор талдаа/ 3м*3м, ханын өндөр шалнаас дээш 2м</li><li>Материал: тоосго, блок, модон</li><li>Ханын зузаан: 38 см</li><li>Ханыг дотор талаас нь шавардаж, цагаан өнгөөр будна</li><li>Худгийн дээвэр 30см*30см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ.(нээлхийг худгийг засвахлахад хэргэлэнэ.)</li></ul> Худгийн цонх нь 40 см*50см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. /цонхны байрлал нь ус өгөх хоолойны чанх харалдаа байрлана
-----	---

2.2	Зэрлэг амьтан ундаалах онгоцонд ус өгөх хоолой нь 60 мм диаметртэй, гаднах ханаас 2м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах
2.3	40 мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.
2.4	Босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1,5м <sup>3</sup> -ээс багагүй багтаамжтай ган усан сан, дээгүүрээ модон тагтай
2.5	Зэрлэг амьтан ундаалах онгоц /2 ширхэг/ <ul style="list-style-type: none"> <li>• Хэмжээ: 6м-ээс багагүй урттай, 400мм-ийн голчтой хагас цилиндр</li> <li>• Материал: Ган хоолой буюу цутгамал төмөр бетон</li> <li>• Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна.</li> <li>• Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана.</li> <li>• Нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ</li> <li>• Усан сангийн зэрлэг амьтан услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнана.</li> </ul> Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна.
<b>3. Худгийн насос, цахилгаан үүсгүүр /2 худагт/</b>	
3.1	Гүний насос ISO 9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх
3.2	Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2 м тутамд хавчиж/туузаар ороож болохгүй/ тогтооно.
3.3	Хянах самбар: Асаах унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйш /улаан/ гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай
3.4	Цахилгаан үүсгүүр: нарны цахилгаан үүсгүүрээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх
<b>4. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх</b>	
4.1	Талбайг цэвэрлэх/ өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/
4.2	Худаг, гүний насос, жижиг ховрын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх, талбайн сургалт хийх
4.3	Усны шинжилгээнд хамруулсан баримтын хавсаргах
4.4	Баталгаат хугацаа 3 жил баталгаат хугацааны үед ашиглалтаас үүдэн гарсан гэмтэл саатал гарсан тохиолдолд шуурхай цаг алдалгүй засвар үйлчилгээ хийнэ гэдэгээ албан тоотоор баталгаажуулж ирүүлэх.
Онцгой нөхцөл	
-Газар хөдлөлтийн 5 баллд тэсвэртэй, газар хөдлөлийн үеийн аюулгүй байдал нөхцөл шаардлагыг хангасан барилга, байгууламж -Байгаль цаг уурын үзүүлэлтэд тулгуурлан үер бороо, үерийн усны хамгаалалт төлөвлөгдсөн	

БОЛОВСРУУЛСАН

З.БАЯРЖАРГАЛ